

АЖЛЫН УДИРДАМЖ

Японы Хүүхдийг Ивээх Сан

Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь:
Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх
сургалтын модуль боловсруулах ажлын удирдамж

1. Төслийн хураангуй

[Төслийн нэр]	Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь
[Төслийн хугацаа]	2024 оны 3-р сарын 30 - 2025 оны 3-р сарын 29
[Төслийн санхүүжүүлэгч]	Япон улсын Гадаад хэргийн яам
[Хамтрагч талууд]	ЭМЯ, ХНХЯ, БШУЯ
[Төслийн зорилтот газар]	Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Баянхонгор, Сэлэнгэ аймаг

2. Төслийн зорилго, зорилтууд

Монгол Улсын Эрүүл Мэнд, Боловсрол, Шинжлэх ухаан, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлалыг"-ын дагуу нийслэлийн гурван дүүрэг болон Баянхонгор, Сэлэнгэ аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, оролцоо хөгжлийн дэмжлэгийг цогц байдлаар хэрэгжүүлэх.

Төслийн зорилтууд

- Эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог сайжруулах, чадавхыг бэхжүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын чадавхыг бэхжүүлэх
- Цэцэрлэгийн чадавхыг бэхжүүлэх, тогтолцоог хөгжүүлэх, бага сургуульд шилжихэд дэмжлэг үзүүлэх
- Эцэг эхчүүд болон орон нутгийн иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа
- Бодлогын нөлөөлөл үзүүлэх

3. Үндэслэл, хэрэгцээ шаардлага

Монгол Улсад Эрүүл Мэнд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалал, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлалыг"-ыг 2021 онд шинэчлэн баталсан. Энэ баримт бичиг нь нярайн эрүүл мэндийн үзлэг, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, кейс хэлэлцүүлэг зэрэг Япон улсын хэрэгжүүлсэн төслийн санаачилгад тулгуурлан хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах зорилготой юм.

Энэхүү төслийг боловсруулахдаа төсөл хэрэгжих аймаг, дүүргийн цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, багш нар, эцэг эхчүүдээс санал асуулга, ярилцлагын аргаар холбогдох судалгаа авсан юм.

- Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 62.1% нь хүүхдээ өрхийн эрүүл мэндийн төвийн нярайн эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж байгаагүй, 11.1% нь хүүхдээ дараах шатны эмнэлгийн байгууллагад үзүүлэхийг илүүд үздэг гэжээ. Тэдний 93.1% нь эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэртэй байсан ч 44.8% нь уг гарын авлагаас хөгжлийн талаарх мэдээлэл аваагүй гэж хариулсан байна. Зорилтот өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын 50-аас доошгүй хувь нь 9 сар, 1.5 ба 3 настай хүүхдийн эрүүл мэндийн үзлэг хийхэд их тулгардаг бэрхшээл бол тоног төхөөрөмж, материалын хомсдол, эцэг эхийн ойлголт дутмаг, боловсон хүчний дутагдалтай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд үйлчилгээнд хамрагдахад таатай орчин бүрдүүлэх хэрэгцээтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, оролцоо дэмжлэг үзүүлэх ажлыг удирдан явуулдаг ХБХЭМБНХ-ын салбар комиссуудын хүүхдийн оюун ухаан болон бие бялдрын үйл ажиллагааг сэргээх төдийгүй нийгмийн оролцоог дэмжих, цэцэрлэг, сургуульд хамруулах зэрэг цогц хөгжлийг дэмжих төлөвлөгөө боловсруулах чадавхыг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Төрийн өмчийн цэцэрлэгүүд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй зэргээс үл шалтгаалан хүүхдийн хувийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн боловсрол эзэмшүүлэх шаардлагатай байгааг цэцэрлэгийн багш нартай хийсэн ярилцлагаар тодорхойлогджээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдүүдийн зарим эцэг, эхчүүд хүүхдээ хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүйг хүлээн зөвшөөрөхгүй, зохих оношилгоо, үйлчилгээнд шилжүүлэхээс татгалзаж байгаа тул энэ талаар олон нийтэд таниулах, нөлөөлөл сурталчилгааны ажил шаардлагатай байгааг дурдлаа.

Иймд дээрх хэрэгцээнд үндэслэн бага насны тусгай хэрэгцээтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх цэцэрлэгийн багш, ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх сургалтын гарын авлагыг боловсруулах хэрэгтэй байна.

Ажлын зорилго

1. Зөвлөх баг нь цэцэрлэгийн багш нарт зориулсан тусгай хэрэгцээт хүүхдүүдэд бие бялдар, сэтгэл зүй, суралцах орчны дэмжлэгийг үзүүлэх, цэцэрлэгээс ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах бэлтгэлийг хангах, сургуулийн өмнөх боловсрол дахь тэгш хамруулан сургах сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй, дасгал, сургалтын материал зэргийг багтаасан сургалтын модуль боловсруулна. 1 өдөр (12 цаг)
2. Сургалтын модуль боловсруулах үйл явцад багш нар, төслийн бодлогын болон техникийн шинжээчдийн багийн мэргэжилтнүүдийн саналыг авах, саналыг боловсруулж буй материалд тусгах

3. Боловсруулсан модуль дээр үндэслэн цэцэрлэгийн багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулах
4. Зохион байгуулсан сургалтын мөрөөр багш нарын эзэмшсэн арга зүй, хэрэгжүүлж буй арга барилын өөрчлөлтийг үнэлэх, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах

Сургалтын модулийн агуулга, бүтэц, тавигдах шаардлага

Сургалтын модулийн нэр

Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль (1.5 өдөр/12 цаг)

Сургалтын модулийн агуулга

Бүлэг 1. Цэцэрлэгийн хүртээмжтэй орчин (3 цаг)

- Цэцэрлэгт тэгш хамруулах тухай ойлголт
- Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог, дэмжих арга замууд
- Багш хүүхэд, эцэг эхчүүдэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, эерэг харилцаа бий болгох
- Цэцэрлэг болон анги танхимд хүүхдийн хөгжлийг дэмжих хүртээмжтэй орчин бүрдүүлэх

Бүлэг 2. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан суралцах таатай орчин бүрдүүлэх (6 цаг)

- Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдийг дэмжих ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй
- Анги танхимд хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулах сургалтын арга зүйг хэрэгжүүлэх
 - Сургалтын үйл ажиллагааны стратеги, практик арга замууд
 - Хүүхдийн суралцахуйн үнэлгээ
 - Багшийн өөрийн үнэлгээ
 - Хүүхдэд эерэг зан үйл, дадлыг хэвшүүлэх
 - Харилцаа, нийгэмшихүйн чадварыг хөгжүүлэх
- Хүүхдийн хувийн хөгжлийн хавтас бүрдүүлэх, хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах арга зүй

Бүлэг 3. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах (3 цаг)

- Тусгай хэрэгцээтэй хүүхдэд үзүүлэх цэцэрлэгийн дэмжлэгийн багийн дэмжлэгийн үйл ажиллагаа, өрхийн эмнэлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамтын ажиллагаа
- Тусгай хэрэгцээтэй хүүхэд цэцэрлэгээс ерөнхий боловсролын сургуульд шилжих шилжилтийн үе, онцлог, хүүхдийн хувийн хөгжлийн мэдээллийг бүрдүүлэх
- Шилжилтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх

- Сургуульд бэлэн байдлын үнэлгээ
- Бага боловсролын багш нартай хамтран ажиллах

Сургалтын модулийн агуулга нь боловсролын салбарын өнөөгийн нөхцөл байдал, баримталж буй сургалтын хөтөлбөр, арга зүй, стратегийг тусгасан байх мөн арга зүй, дадлага даалгавар нь жендерт суурилсан онцлог, хэрэгцээг харгалзан тусгасан байна.

Сургалтын модуль нь сургалтын өмнөх болон дараагийн мэдлэг, дадлага сорих даалгавартай байна.

Сургалтын модулийн бүтэц

Бүтэц	Агуулга	
Модулийн зорилго	Хүрэх үр дүн	
Агуулгын бүрэлдэхүүн	Сургалтад оролцогчид ямар мэдлэг, чадвар эзэмших	
	Суралцагчдад өгөх мэдээлэл	Танилцуулах мэдээллийн агуулга
	Ашиглах материал	Тараах материал, видео, ашиглах хэрэгсэл
	Арга зүй	Сургалт хэрхэн явагдах аргачлал Ашиглах сургалтын аргууд Дасгал ажил, бүтээлч тоглоомууд г.м
Үнэлгээ дүгнэлт	Сургалтад оролцогчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх сургалтын өмнөх болон дараах сорил	
Хавсралт	Гарын авлагын агуулгаар бэлтгэсэн танхимын болон онлайн сургалтын танилцуулга, унших материал, видео дасгал даалгавар, сорил	

Багийн ажил үүргийн хуваарь

- Ажил гүйцэтгэх баг нь Японы Хүүхдийг Ивээх сангийн “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн ажилтнуудын техникийн туслалцааг авч, байнга зөвшилцөж ажиллана.
- Мөн төслийн хүрээнд боловсруулагдаж байгаа бусад модуль, гарын авлага боловсруулах зөвлөх багуудтай нягт хамтран ажиллана.

Төслийн багт хүлээлгэн өгөх материал

Зөвлөх баг нь дараах материалуудыг бэлтгэн төслийн багт хүлээлгэн өгнө. Үүнд:

- Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль
- Багш нар, төслийн ажлын хэсгийн гишүүд, бусад холбогдох төлөөллийн оролцуулсан уулзалт, сургалт зохион байгуулсан тайлан

- Сургагч багш нарын сургалт зохион байгуулсан тайлан

Ажлын хүрээ, хугацаа

Зөвлөх баг нь дараах ажлын хүрээг баримтлан ажиллана.

ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД	ХУГАЦАА
Бэлтгэл үе шат	
Зөвлөх ажлын нөхцөлийн талаар тохиролцох (Ажлын гэрээ, гүйцэтгэх ажил, хуваарь гэх мэт)	VI/14
Төслийн чиглэл, үзэл санаатай танилцах	
Гэрээнд гарын үсэг зурах	VI/20
Гарын авлага боловсруулах шат	
Сургалтын модулийн дизайн, бүлэг тус бүрийн агуулгыг боловсруулах	VII/08
Сургалтын модулийн дизайн, агуулгыг төслийн багаас санал авч хэлэлцүүлэх	
Холбогдох санал хүсэлтүүдийг тусган засан сайжруулах	VII/22
Сайжруулсан хувилбарыг төслийн баг болон техникийн шинжээчийн төлөөллөөр хэлэлцүүлэх, эцсийн санал өгөх	VII/28
Гарын авлагыг эцэслэн боловсруулж дуусгах	
Боловсруулсан материалуудыг ХИС-нд цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх	VIII/05
Боловсруулсан төслийг хэвлэлд шилжүүлэх, хэвлэлийн эх бэлтгэхэд хамтран ажиллах, гэрээг дүгнэх	VIII/15
Сургагч багш бэлтгэх семинар зохион байгуулах	
УБ хотод цэцэрлэгийн багш нарт сургалт зохион байгуулах	VIII/20-25
Сургалтын тайлан бичиж өгөх	IX/01

Зөвлөх баг болон багийн гишүүнд тавигдах ерөнхий шаардлага:

- Баг нь 3-аас дээш гишүүнтэй байх
- Сургуулийн өмнөх болон бага боловсролын салбарт 5 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх
- Багийн гишүүд нь сургалтын хөтөлбөр, гарын авлага, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж байсан туршлагатай байх
- Тэгш хамруулан сургах чиглэлээр гарын авлага боловсруулж байсан туршлагатай байх
- Компьютерын оффис програмууд дээр чөлөөтэй ажиллах чадвартай байх
- Багаар ажиллах чадвартай байх
- Төслийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зорилтот сургууль, хөдөө орон нутагт очиж зөвлөгөө өгөх, хяналт-үнэлгээний багийн бүрэлдэхүүнд орж ажиллах боломжтой байх

- Багийн гишүүд нь ХИС-ийн өмнөх Тэгш хамран сургах боловсролын төслийн сургалтын материал/модуль боловсруулж байсан мөн боловсролын мастер зэрэгтэй бол давуу тал болно

ИРҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Шалгаруулалтад оролцох хүсэлтийг илэрхийлсэн албан захидал
- Багийн танилцуулга (багийн гишүүдийн мэдээлэл, анкет, гол хариуцах хүний мэдээлэл)
- Ижил төстэй ажлыг хийж, боловсруулж байсан туршлага (мэдээлэл, жишээ болохуйц бүтээлийн жагсаалтууд)
- Ажлыг гүйцэтгэх үнийн санал